

**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2025 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

/2025 оны жилийн эцэс/

2025 оны 12 дугаар сарын 15

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинийг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 38 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Гэрээ, эрх зүй хүний нөөцийн хэлтсээс 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилтын 38 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 91,8 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- ЗОРИЛТ 1. Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийг бүрэн ашиглалтад оруулах зорилт хамаарах 9 арга хэмжээний хэрэгжилт – 67,6%;

- ЗОРИЛТ 2. Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилэх зорилтод хамаарах 3 арга хэмжээний хэрэгжилт – 76,6 %;

- ЗОРИЛТ 3. Чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, газрын харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавихад хамаарах 8 арга хэмжээний хэрэгжилт – 98.7%;

- ЗОРИЛТ 4. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд хамаарах 2 арга хэмжээний хэрэгжилт – 100%;

- ЗОРИЛТ 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилт, арга хэмжээнд хамаарах 6 арга хэмжээний хэрэгжилт – 100%;

- ЗОРИЛТ 6. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийн технологи, мэдээллийн

сүлжээ, санг хөгжүүлэх, найдвартай ажиллагааг хангах зорилт, арга хэмжээнд хамаарах 4 арга хэмжээний хэрэгжилт – 100%;

- ЗОРИЛТ 7. Чөлөөт бүсийн бүртгэл санхүү, төсвийн удирдлагыг хангах зорилт, арга хэмжээнд хамаарах 6 арга хэмжээний хэрэгжилт - 100.0% байна.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ /2025 оны жилийн эцэс/

**Дөрөв. Дүгнэлт.**

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилгын 38 зорилт арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийг 91,6 хувийн биелэлттэй гэж дүгнэв.

2. Нийт 38 арга хэмжээний биелэлтийг дүгнэхэд 32 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээ 30 хувь, 2 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

**Тав. Зөвлөмж.**

1. Зарим арга хэмжээг төлөвлөхдөө тухай онд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлж, нарийвчлан төлөвлөх

2. Хэрэгжээгүй, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

3. Арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй болон биелэлтийг дутуу тайлагнах, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах

Жич: “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээг хавсаргав.

Танилцсан: Захирагчийн ажлын албаны дарга

Ш.Амартүвшин

Хянасан: Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга

Б.Ономаа

Боловсруулсан: Мэргэжилтэн

Ч.Баттулга